



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/95/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 210

танай _____ ны № _____ т

**БУЛГАН СУМЫН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН ДАРГА
О.БУЯННЭМЭХ ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баталгаажуулсан санхүүгийн тайланг хуулийн цаглаварт хугацаанд ирүүлээгүй, хуваарьт хугацаанд аудтын нотлох баримт, анхан шатны баримтыг ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолын нэмэлт өөрчлөлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны XII/01 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын XVII/03 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна.

006020480

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Булган сумын Тохижилт үйлчилгээний анги 1 хөтөлбөр 5 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,038.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 1,038.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	30,687,961.0	35,094,170.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,965,517,845.8	7,291,260,654.0
	Нийт хөрөнгийн дүн	9,996,205,806.8	7,326,354,824.4
	Нийт өр төлбөрийн дүн	1,340,505.0	137,255.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,994,865,301.8	7,326,217,569.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,996,205,806.8	7,326,354,824.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	35,094,170.4	30,687,961.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	7,291,260,654.0	9,965,517,845.8
	Үйл ажиллагааны үр дүн	7,326,354,824.4	9,996,205,806.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	7,326,217,569.4	9,994,865,301.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,781,985,048.6	7,326,217,569.4
	Тайлант оны үр дүн	(1,455,767,479.2)	2,668,647,732.4
	Эцсийн үлдэгдэл	7,326,217,569.4	9,994,865,301.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	639,526,380.0	1,059,868,540.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	639,526,380.0	1,059,868,540.0
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,038,049,444.4
	Урсгал зардал	-	1,038,049,444.4
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,038,050,200.0
	Улсын төсвөөс санхүүжих	-	1,038,050,200.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 460,318.9 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- 3 нэгж талбар бүхий 20,49 га 457,100.0 мянган төгрөгийн газрыг тайлан бүртгэлд тусгаагүй нь УСНББОУС-17, иж бүрэн байх батламж мэдэгдэл,
- Тайлант хугацаанд 18.8 мянган төгрөгийн авлага дутуу бүртгэсэн нь УСНББОУС-1, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 200.2 мянган төгрөгийн өглөгийг илүү тусгасан нь УСНББОУС-1, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Бараа материалыг орлогоор хүлээн зөвшөөрөхдөө алдаатай бүртгэсэн нь УСНББОУС-1, 12, тохиолдсон байх мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 12,711.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2 албан шаардлага, 10,024.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,005,734.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 971,49164 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

3.2 Албан шаардлага

1. Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 39 төрлийн 993,022.2 мянган төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй, данс бүртгэлээс хас ажлыг зохион байгуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй нь Аймгийн ИТХ-ын 2014 оны 17 дугаар тогтоолын хавсралтын 6.1, 6.2, 2018 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 2.4, 2.5 гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх, данс бүртгэлээс хас ажлыг зохион байгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлэх.

3.3 Зөвлөмж

1. Журам батлалгүйгээр албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3-р хавсралтын 2.6-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн үйлчилгээний албан хаагчийг үнэлж олгох үр дүнгийн урамшууллын журам баталж албан хаагчдыг үнэлэх

2. Санхүүгийн тайланг хуулийн цаглаварт хугацаанд ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Булган сум ТҮА	4	460.3	2	457.1	2	3.2	4	460.3	0	0	0	0
Дүн	4	460.3	2	457.1	2	3.2	4	460.3	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Булган сум ТҮА	4	12.7	0	-	2	2.7	2	10.0	0	-	0	-
Дүн	4	12.7	0	-	2	2.7	2	10.0	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Булган сум ТҮА	1	417.2			1	417.2		
Дүн	1	417.2	0	0	1	417.2	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Булган сум ТҮА	2	0	0	0	0	0	2	0
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Нийт дүн	3	417.2	0	-	1	417.2	2	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

-оОо-